



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндуг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: coo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Зөвлөмж.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
БигГ	Гаалийн ерөнхий газрын харьяа Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН БИЧИГТ ДЭХ
ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Н.АМАРБААТАР ТАНАА**

2022. 02. 24 № 47

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойшхи үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Улсын төсвийн санхүүжилтээр 717,766.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн гүйцэтгэл 596,835.6 мянган төгрөг зарцуулж, 120,930.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотойгоор "Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 221,780.8 мянган төгрөг буюу 24.2 хувиар өссөн нь ТӨБЗГ-ын 90 тоот тогтоол, ГЕГ-ын даргын А/35 тоот тушаалаар Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 314,580.1 төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлж, үнэ төлбөргүй хүлээн авсан"-аас өөрөөр нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 8 хөтөлбөрийн хүрээнд 46 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 85.8 хувьтай үнэлэгдсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20 231 628,00</u>	<u>46 532 769,15</u>
33	АВЛАГА	-	823 467,15
335	Бусад авлага	-	823 467,15
3351	Байгууллагаас авах авлага	-	823 467,15
35	БАРАА МАТЕРИАЛ	20 231 628,00	45 709 302,00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5 065 503,00	9 491 503,00
354	Хангамжийн материал	12 664 125,00	30 882 799,00
35410	Бичиг хэргийн материал	554 100,00	448 100,00
35420	Аж ахуйн материал	8 330 670,00	11 838 070,00
35440	Түлш, шатах тослох материал	915 250,00	2 772 000,00
35470	Бусад хангамжийн материал	2 864 105,00	15 824 629,00
35600	Мал амьтад	2 502 000,00	5 335 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2 333 081 617,43</u>	<u>2 253 033 151,78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 333 081 617,43	2 253 033 151,78
392	Биет хөрөнгө	2 013 656 285,43	1 922 731 550,02
39201	Барилга, байгууламж, орон сууц	2 007 045 713,93	2 041 716 423,53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(515 089 056,13)	(573 022 699,35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	130 000 000,00	130 000 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21 666 666,72)	(43 333 333,44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	801 480 152,92	1 078 745 279,02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(409 272 181,73)	(728 666 426,80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9 259 227,00	9 830 424,50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8 814 445,43)	(9 714 158,99)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27 150 000,00	27 150 000,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6 436 458,41)	(9 973 958,45)
393	Биет бус хөрөнгө	319 425 332,00	330 301 601,76
39301	Програм хангамж	39 989 207,00	45 573 285,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(621 875,00)	(4 819 683,24)
39303	Бусад биет бус хөрөнгө	280 058 000,00	289 548 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2 353 313 245,43</u>	<u>2 299 565 920,93</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2 353 313 245,43</u>	<u>2 299 565 920,93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2 353 313 245,43	2 299 565 920,93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2 313 613 220,61	2 323 103 220,61
51101	Өмч: - төрийн	2 313 613 220,61	2 323 103 220,61
512	Хуримтлагдсан үр дүн	39 243 382,98	(23 993 941,52)
51210	Өмнөх үеийн үр дүн	158 111 400,01	39 243 382,98
51220	Тайлант үеийн үр дүн	(118 868 017,03)	(63 237 324,50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	456 641,84	456 641,84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2 353 313 245,43</u>	<u>2 299 565 920,93</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	694 239 308,87	916 020 123,22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103 989 508,87	198 753 523,22
120	Нийтлэг татварын бус орлого	103 989 508,87	198 753 523,22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22 420 454,90	15 006 828,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22 420 454,90	15 006 828,00
120009	Бусад орлого	81 569 053,97	183 746 695,22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	590 249 800,00	717 266 600,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	590 249 800,00	717 266 600,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	590 249 800,00	717 266 600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	813 074 215,90	977 963 033,72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	813 074 215,90	977 963 033,72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684 005 724,50	842 065 233,66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323 092 807,39	414 400 498,76
210101	Үндсэн цалин	157 179 706,17	193 559 329,86
210102	Нэмэгдэл	129 462 744,22	145 760 137,90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17 827 000,00	37 063 000,00
210104	Урамшуулал	18 623 357,00	38 018 031,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41 924 532,01	52 336 968,59
210201	Тэтгэврийн даатгал	29 010 935,41	35 779 135,19
210202	Тэтгэмжийн даатгал	2 584 295,16	3 345 311,27
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 230 369,18	4 164 839,22
210204	Ажилгүйдлийн даатгал	645 357,44	829 389,36
210205	Эрүүл мэндийн даатгал	6 453 574,82	8 218 293,55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83 562 433,96	82 922 449,44
210301	Гэрэл, цахилгаан	63 207 683,96	61 713 599,44
210302	Түлш, халаалт	20 163 500,00	21 103 250,00
210303	Цэвэр, бохир ус	191 250,00	105 600,00
2104	Хангамж, бараа материалын зардал	18 129 423,11	11 322 310,00
210401	Бичиг хэрэг	2 342 380,00	1 500 300,00
210402	Тээвэр, шатахуун	7 470 015,00	8 460 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64 300,00	20 660,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		107 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 656 450,00	1 233 850,00
2105	Нормативт зардал	-	9 147 500,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		9 147 500,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11 577 900,00	15 847 649,00
210601	Багаж, техник, хэрэгсэл		131 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6 752 100,00	8 517 249,00
210604	Урсгал засвар	4 825 800,00	7 199 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5 607 530,00	5 945 735,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		648 000,00
210803	Даатгалын үйлчилгээ		64 350,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211 825,00	113 600,00
210807	Газрын төлбөр		2 895 484,00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4 651 705,00	2 224 301,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200 111 098,03	250 142 122,87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	488 260,00	1 172 000,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	199 622 838,03	248 970 122,87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129 068 491,40	135 897 800,06
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	400 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		400 000,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	129 068 491,40	135 497 800,06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	129 068 491,40	135 497 800,06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(118 834 907,03)</u>	<u>(61 942 910,50)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33 110,00	1 294 414,00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	33 110,00	1 294 414,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(33 110,00)	(1 294 414,00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(118 868 017,03)</u>	<u>(63 237 324,50)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>607 875 054,90</u>	<u>732 273 428,00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17 625 254,90	15 006 828,00
120	Нийтлэг татварын бус орлого	17 625 254,90	15 006 828,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17 625 254,90	15 006 828,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17 625 254,90	15 006 828,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	590 249 800,00	717 226 600,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	590 249 800,00	717 226 600,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	590 249 800,00	717 266 600,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>607 875 054,90</u>	<u>732 273 428,00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	607 875 054,90	732 273 428,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483 601 763,50	596 375 627,94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323 149 512,31	414 400 500,20
210101	Үндсэн цалин	186 692 124,39	211 293 979,74
210102	Нэмэгдэл	99 014 954,36	117 184 926,47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14 824 500,00	39 932 107,86
210104	Урамшуулал	22 617 933,56	45 989 486,13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41 837 342,23	52 336 967,15
210201	Тэтгэврийн даатгал	28 749 270,09	35 758 133,23
210202	Тэтгэмжийн даатгал	3 182 386,04	4 206 839,32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 806 753,69	3 331 871,33
210204	Ажилгүйдлийн даатгал	645 357,45	821 829,38
210205	Эрүүл мэндийн даатгал	6 453 574,96	8 218 293,89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83 045 333,96	85 602 666,59
210301	Гэрэл, цахилгаан	63 207 683,96	62 537 066,59
210302	Түлш, халаалт	19 480 500,00	22 960 000,00
210303	Цэвэр, бохир ус	357 150,00	105 600,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9 028 750,00	11 341 860,00
210401	Бичиг хэрэг	1 206 450,00	1 034 100,00
210402	Тээвэр, шатахуун	6 300 000,00	8 460 000,00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64 300,00	20 660,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	112 000,00	236 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 346 000,00	1 590 600,00
2105	Нормативт зардал	-	12 575 000,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	12 575 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25 585 000,00	16 397 200,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5 809 100,00	582 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4 310 100,00	2 207 200,00
210604	Урсгал засвар	15 465 800,00	13 608 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	955 825,00	3 721 434,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	744,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	648 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	-	64 350,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211 825,00	113 600,00
210807	Газрын төлбөр	-	2 895 484,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124 273 291,40	135 897 800,06
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	400 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	400 000,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	124 273 291,40	135 497 800,06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	124 273 291,40	135 497 800,06
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>15,045,000,00</u>	<u>0,00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>=====</u>	<u>=====</u>
8	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2 033 555 220,61	456 641,84	158 111 400,01	2 192 123 262,46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9 490 000,00	0,00	0,00	9 490 000,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 043 045 220,61	456 641,84	158 111 400,01	2 201 613 262,46
C07	Тайлант үеийн үр дүн			-118 868 017,03	-118 868 017,03
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 043 045 220,61	456 641,84	39 243 382,98	2 082 745 245,43
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2 043 045 220,61	456 641,84	-79 624 634,05	2 082 745 245,43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9 490 000,00	0,00	0,00	9 490 000,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 052 535 220,61	456 641,84	39 243 382,98	2 092 235 245,43
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-63 237 324,50	-63 237 324,50
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 052 535 220,61	456 641,84	-23 993 941,52	2 028 997 920,93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	717 766 600,00	596 835 627,94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	717 766 600,00	596 835 627,94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717 366 600,00	596 435 627,94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	493 954 100,00	414 400 500,20
210101	Үндсэн цалин	256 891 700,00	211 293 979,74
210102	Нэмэгдэл	149 058 400,00	117 184 926,47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32 604 000,00	39 932 107,86
210104	Урамшуулал	55 400 000,00	45 989 486,13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62 794 200,00	52 336 967,15
210201	Тэтгэврийн даатгал	45 344 100,00	35 758 133,23
210202	Тэтгэмжийн даатгал	4 362 500,00	4 206 839,32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 490 000,00	3 331 871,33
210204	Ажилгүйдлийн даатгал	872 500,00	821 829,38
210205	Эрүүл мэндийн даатгал	8 725 100,00	8 218 293,89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106 576 700,00	85 662 666,59
210301	Гэрэл, цахилгаан	76 266 700,00	62 597 066,59
210302	Түлш, халаалт	28 880 000,00	22 960 000,00
210303	Цэвэр, бохир ус	1 430 000,00	105 600,00
2104	Хангамж, бараа материалын зардал	13 150 300,00	11 341 860,00
210401	Бичиг хэрэг	1 253 300,00	1 034 100,00
210402	Тээвэр, шатахуун	9 496 700,00	8 460 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360 000,00	20 660,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	381 300,00	236 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 659 000,00	1 590 600,00
2105	Нормативт зардал	13 400 000,00	12 575 000,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13 400 000,00	12 575 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25 313 300,00	16 397 200,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1 881 300,00	582 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3 432 000,00	2 207 200,00
210604	Урсгал засвар	20 000 000,00	13 608 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 000 000,00	-
210702	Дотоод албан томилолт	1 000 000,00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 178 000,00	3 721 434,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648 000,00	648 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	200 000,00	64 350,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230 000,00	113 600,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100 000,00	-
210807	Газрын төлбөр	-	2 895 484,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400 000,00	400 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400 000,00	400 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400 000,00	400 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	724 266 600,00	732 273 428,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	717 266 600,00	717 266 600,00

131001	Улсын төсвөөс санхүүжих	717 266 600,00	717 266 600,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7 000 000,00	15 006 828,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7 000 000,00	15 006 828,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0,00	0,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0,00	0,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0,00	0,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0,00	0,00
210104	Урамшуулал	0,00	0,00
2104	Хангамж, бараа материалын зардал	0,00	0,00
210401	Бичиг хэрэг	0,00	0,00
210402	Тээвэр, шатахуун	0,00	0,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0,00	0,00
210602	Тавилга	0,00	0,00
210604	Урсгал засвар	0,00	0,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0,00	0,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0,00	0,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0,00	0,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0,00	0,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0,00	0,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0,00	0,00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар нь гаалийн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа явуулдаг Сангийн яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг нь төрийн үйлчилгээний байгууллага бөгөөд Монгол улсын эдийн засаг, хүн ардын аюулгүй байдлыг хамгаалах, улсын төсөв бүрдүүлэх зорилготой.

Байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,747.3 мянган төгрөгөөр буюу 2.33 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	-
Авлага	0.00	823,467.15	823,467.15
Бараа материал	20,231,628.00	45,709,302.00	25,477,674.00
Үндсэн хөрөнгө	2,333,081,617.43	2,253,033,151.78	-80,048,465.65
Нийт хөрөнгө	2,353,313,245.43	2,299,565,920.93	-53,747,324.50
Өр төлбөр	0.00	0.00	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,313,613,220.61	2,313,613,220.61	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,353,313,245.43	2,299,565,920.93	-53,747,324.50

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,253,033.2 мянган төгрөг болж, 80,048.5 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурч, бараа материалын үлдэгдэл 45,709.3 мянган төгрөг болж 25,477.7 мянган төгрөгөөр буюу 55.7 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 221,780.8 мянган төгрөг буюу 24.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. ТӨБЗГ-ын 90 тоот тогтоол, ГЕГ-ын даргын А/35 тоот тушаалаар Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 314,580.1 төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлж, үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 164,888.8 мянган төгрөгөөр буюу 16.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт болон урамшуулалтай холбоотой зардал байна. Цалингийн зардал 36.4 сая төгрөгөөр, нэмэгдэл цалин 16.3 сая төгрөг, унаа хоолны нэмэгдэл 19.2 сая төгрөг, урамшууллын зардал 19.4 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 717,266.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 15,006.8 мянган төгрөг, нийт зарлагыг 977,963.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 46 арга хэмжээг санхүүжүүлэхээр 977,963.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 717,266.6 мянган төгрөг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагааны орлогоос 15,006.8 мянган төгрөгийн төвлөрсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205 80101- Үндсэн үйл ажиллагаа (татвар хураалт, орлого бүрдүүлэлт)	716 266,60	580 768,80	135 497,80	81.08%
2	70205 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	1 000,00	1 000,00	0	100%
	НИЙТ	717 266,60	581 768,80		81,11%

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 81.08 хувьтай хэрэгжсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 15,006.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд 8 хөтөлбөр, зорилтын хүрээнд нийт 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 85.81 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг хавсаргав

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах Д.Сарнай нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-16/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 8,130.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,691.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд газрын төлбөрөөс өөр хэтэрсэн зардал байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар нь 2022 онд нийт 717,266.6 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1.-д “...тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой.” Гэж заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

1. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)-ийг 2022 оны 4 дүгээр сарын 04-ны өдөр байршуулсан
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)-г 2022 оны 4 дүгээр сарын 04-ны өдөр байршуулсан
3. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)-ийг тус тус шилэн дансны цахим системд хугацаа хоцроож байршуулсан.

Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш төгрөгийн зарцуулалт байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газарт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 192,567.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 776.6 мянган төгрөгийн залруулга хийж, 134.0 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд акт тогтоож бүрэн биелүүлсэн, 1,127.6 мянган төгрөгийн 1 зөрчилд өгсөн албан шаардлагын хэрэгжилт 85 хувьтай биелсэн байна.

Зөвлөмжөөр өгсөн элэгдлээр өртгөө нөхсөн 21 нэр төрлийн 190,529.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авч данснаас хасах зөвлөмж өгсөн. Актлаж, данснаас хасах саналыг ТӨБЗГ-т хүргүүлсэн боловч ямар нэгэн шийдвэр гаргаж өгөөгүйн улмаас уг зөвлөмж биелээгүй байна

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Залруулга	1	776.6	1	776.6	100
Акт	1	134.0	1	134.0	100
Албан шаардлага	1	1,127.6	1	1,127.6	85
Зөвлөмж	2	190,529.1	2	-	-
Нийт дүн	5	192,567.3	2	2,038.2	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар аливаа акт, албан шаардлага хүргүүлэх асуудлууд илрээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой. Шилэн дансны цахим системд хугацаа хоцроож байршуулсан дараах мэдээллүүд байна. Үүнд:

1. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)-ийг 2022 оны 4 дүгээр сарын 04-ны өдөр,
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)-г 2022 оны 4 дүгээр сарын 04-ны өдөр
3. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хугацаа хоцорч мэдээлсэн	3	-	-	-	-	-	3	-
Дүн	3	-	-	-	-	-	3	-